



Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хороонд илгээх зэрэгцээ тайлан

НҮБ-ын Эрүүдэн Шүүхийн Эсрэг Конвенци(ЭШЭК)-д нэгдэн орсон бүх улс орон Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хороо (ЭШЭХ)-нд тогтмол тайлан хүргүүлж байх үүрэгтэй. ЭШЭХ тайланг хэлэлцэх үеэр тухайн улс конвенциор хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа тухайгаа тайлагнах ёстой бөгөөд Хорооноос цаашид конвенцийн хэрэгжилтийг сайжруулахад шаардлагатай арга хэмжээний талаар зөвлөмж гаргадаг.

Зэрэгцээ тайлан нь ТББ-уудын зүгээс өөрийн улсын тайланг ЭШЭХ-гоор хэлэлцэх үйл явцад оролцох, ингэснээрээ тухайн улс конвенциор хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх арга хэрэгсэл болдог. Зэрэгцээ тайлангийн зорилго бол засгийн газрын тайланг орлох явдал бус харин тайланг хэлэлцэх явцад нэмэлт дүн шинжилгээний үүрэг гүйцэтгэх явдал юм.


1. ТББ-ууд хэрхэн оролцож болох вэ?

Хорооны зүгээс ТББ-уудад тайлангийн мөчлөгийн стандарт болон нэмэлт процедурт оролцох (ЭШЭК-ийн 19-р зүйл) тусгай боломжийг олгодог. Конвенцид нэгдэн орсон улсууд түүнийг соёрхон баталснаас хойш нэг жилийн дараа анхны тайлан, түүнээс хойш дөрвөн жил тутам ЭШЭК-ийн зүйл заалтыг дотоодын хууль тогтоомж болон практикт хэрхэн хэрэгжүүлж байгаа тухайгаа илтгэсэн тогтмол тайланг ирүүлж байх үүрэгтэй. Тайлангийн мөчлөг нь соёрхон баталсан мөчөөс эхлэх бөгөөд ТББ-ууд энэ мөчөөс эхлэн уг үйл явцад оролцох боломжтой юм.

Тайлангийн ердийн процедур

Тайлангийн ердийн процедурын хувьд тайланг хүлээн авсны дараа ЭШЭХ Асуудлын жагсаалтыг баталж, нэгдэн орсон улсад өгөх бөгөөд тухайн улсын бичгээр ирүүлсэн хариултыг ЭШЭХ-ны хурлаар хэлэлцэнэ. Түүний дараа ЭШЭХ ерөнхий дүгнэлт, зөвлөмж гаргах ба тэдгээрийн заримын хэрэгжилтийг тухайн улс нэг жилийн дотор эргэж тайлагнах үүрэг хүлээдэг.

Хүний эрхийн гэрээ конвенцид тусгагдсан тайлангийн мөчлөг



Зураг: Тайлангийн мөчлөгийн ердийн процедур¹


Тайлангийн нэмэлт процедур

Нэгдэн орсон улс хүсвэл тайлангийн нэмэлт процедурыг ердийн процедурын оронд хэрэглэж болно. Ингэхдээ ЭШЭХ тайлан ирүүлэх хугацаанаас нэг жил хагасын өмнө Тайлангаас Өмнөх Асуудлын Жагсаалт (ТӨАЖ)-ыг тухайн улсад гаргаж өгнө. Конвенцийн 19-р зүйлд заасан ёсоор ТӨАЖ-д хариулт өгөх нь Хороонд тайлагнах үүргээ биелүүлж байна гэсэн хэрэг юм.

Өмнө дурдсан ердийн процедурын нэгэн адил Хороо эдгээр асуудлыг хурлаараа хэлэлцэж, дүгнэх санал болон зөвлөмж гаргах ба зөвлөмжийн хэрэгжилтийг нэг жилийн дотор эргэн хэлэлцдэг. Энэ тохиолдолд ТББ-ууд зэрэгцээ тайлан гаргах боломжийг адилхан эдэлдэг.

¹<http://www2.ohchr.org/english/bodies/docs/ReportingCycle.gif>

**Эрүүдэн шүүхийн эсрэг
Хороонд тайлагнах
мөчлөгийн нэмэлт процедур**



Зураг: Тайлангийн мөчлөгийн нэмэлт процедур

Ердийн болон нэмэлт процедурын аль алины хувьд ТББ-ууд ЭШЭХ-нд өөрсдийн бичсэн тайлан болон бусад баримт бичгийг дараах зорилгоор илгээж болно:

- Конвенцид нэгдэн орсон улсад илгээх Асуудлын Жагсаалт (АЖ) буюу Тайлангаас Өмнөх Асуудлын Жагсаалт (ТӨАЖ)-ыг батлахад туслах,
- Хэлэлцүүлгийн үеэр тухайн улсын тайланг шинжлэхэд,
- Эсхүл зөвлөмжийн хэрэгжилт хэрхэн явагдаж байгаа талаар мэдээлэл өгөх.

Дараах удирдамж нь ТББ-ууд Хороонд зэрэгцээ тайлан бэлтгэж өгөхөд туслах зорилготой юм. ТББ-ууд тайлангийн аман хэлэлцүүлэгт биечлэн оролцох зэргээр ЭШЭХ-ны үйл ажиллагаанд оролцох бусад боломж бий. Энэ нь ТББ-уудын хувьд асуудлаа Хороонд танилцуулах таатай боломж юм. ТББ-ууд Хорооны үйл ажиллагаанд оролцох боломжийн талаар нэмэлт мэдээллийг Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын вэб хуудасны “ТББ-ууд ба Үндэсний Хүний Эрхийн Комиссуудад зориулсан мэдээлэл” хэсгээс авч болно.²

² http://www2.ohchr.org/english/bodies/cat/follow_up_ngo.htm

2. Зэрэгцээ тайлан – ерөнхий заавар

Дээр дурдсанчлан зэрэгцээ тайлан нь ТББ-ын зүгээс НҮБ-ын гэрээ конвенцийн тайлагналтын процессын үр дүнг дээшлүүлэх, хэрэгжилттэй холбоотой хүндрэлийг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах ач холбогдолтой зүйл юм. ТББ-ууд өөрийн улсын тайланд дурдсан мэдээлэлтэй холбоотой асуудлаар саналаа илэрхийлэх нь зүйтэй бөгөөд учир нь ЭШЭХ-нд ирүүлсэн тайлангууд бүрэн гүйцэт биш байх нь элбэг байдаг. Тийм ч учраас ТББ-ууд ЭШЭХ-г нэмэлт мэдээллээр хангаж, илүү бүрэн дүүрэн шинжилгээ хийж, тухайн асуудлыг олон өнцгөөс харах боломж олгох ёстой.

Доор дурдсан зааварт бүх зүйлийг орхилгүй багтаасан гэж үзэж болохгүй. Зааварт дурдсан зүйлсийг бүгдийг нь зэрэгцээ тайланд тусгах нь зүйтэй боловч тухайн ТББ ямар асуудалд голлон анхаарч байгаагаас шалтгаалж зарим зүйлсийг илүү онцлох шаардлагатай болохыг үгүйсгэхгүй.

а. Тайланг Хянан Хэлэлцэх Хороо ба нэгдэн орсон улсын тайлан

ЭШЭХ тухайн улсын түрүүчийн тайланг хэлэлцээд гаргасан зөвлөмж болон тухайн улсаас Хороонд ирүүлсэн мэдээллийг авч үзэх нь зүйтэй. Тухайн улс тэдгээр зөвлөмжийг хэрхэн биелүүлж, амлалтаа хэрхэн биелүүлсэн бэ? Өөрийн орны өмнөх болон одоогийн тайлан, Хорооноос гаргасан дүгнэлт санал, зөвлөмж, АЖ, ТӨАЖ зэрэг баримт бичгийн хувийг олж авах нь чухам ямар мэдээлэл, ямар асуудлыг тайландаа тусгах, ЭШЭХ-ны зүгээс засгийн газарт ямар асуулт тавихыг тодорхойлоход тус дөхөм болдог.

б. НҮБ-ын ЭШЭК болон Хорооноос гаргасан ерөнхий саналыг шинжлэх нь

Хороо нь зөвхөн өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар ТББ-уудаас ирүүлсэн мэдээллийг авч хэлэлцдэг. Конвенцийн хэрэгжилтэд үл хамаарах ямар ч асуудлыг авч үздэггүй. Тийм ч учраас, конвенцийн зүйл заалт хийгээд Хорооноос гаргасан ерөнхий саналууд, мөн өөрийн улсын хийсэн аливаа тайлбар, мэдэгдлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй байх нь тус улсын үүрэг хариуцлагыг бүрэн дүүрэн ойлгоход ихээхэн чухал байдаг.

с. Тайлангийн хэл

ТББ-ын тайланг орчуулдаггүй учраас НҮБ-ын албан ёсны аль нэг хэлээр (Англи, Араб, Испани, Орос, Франц, Хятад) бичигдсэн байх ёстой. Хэрэв тайланг хэд хэдэн хэлээр орчуулах боломжгүй бол Англи хэлээр ирүүлэх нь зүйтэй. Хорооны гишүүдийн дийлэнх нь Англи хэлийг ажлын хэл болгон ашигладаг тул энэ нь хамгийн өргөн хүрээнд тараах боломж олгодог.

д. Бүх зэрэгцээ тайланг хэвлэдэг

ЭШЭХ ТББ-аас ирүүлсэн бүхий л мэдээллийг хүлээн авсныхаа дараа өөрийн вэб хуудсанд нийтэлдэг. Тийм учраас хохирогчдын болон тэдний гэр бүлийн нэрсийг өөрсдийнх нь зөвшөөрөлгүйгээр дурдах ёсгүй.

е. Тайлан илгээх хугацаа

ТББ-ууд зэрэгцээ тайлангаа хангалттай хугацааны өмнө Хорооноос тогтоосон тайлан хүлээн авах хугацаанд бэлтгэхээр төлөвлөх нь зүйтэй. Эцсийн хугацааг дараах шалгуурыг үндэслэн тогтоодог:

i. Хороонд АЖ болон ТӨАЖ-ыг батлахад нь туслах зорилготой тайланг тэдгээр жагсаалтыг батлах хуралдаан эхлэхээс 10 долоо хоногийн өмнө ирүүлнэ.

ii. Нэгдэн орсон улсын тайлантай холбоотой тайланг тухайн улсын тайланг хэлэлцэх хуралдаан эхлэхээс 2 долоо хоногийн өмнө ирүүлнэ.

ЭШЭХ тухайн жилийн туршид нэмэлт процедурыг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдлийг улсуудаас хүлээн авч болно гэдгийг санахад илүүдэхгүй. Тийм ч учраас Хорооны дараачийн хурлаар ТӨАЖ-ыг нь батлах орнуудын жагсаалтыг нэлээд хожуу гаргах нь бий. Тиймээс тухайн улсын ТӨАЖ 5-р сар буюу 11-р сарын хурлын алианаар нь батлагдахыг урьдчилан хэлэхэд төвөгтэй байдаг. Хорооны Нарийн Бичгийн Даргын Газар чухам тийм учраас ТББ-уудад тухайн жилд асуудлын жагсаалт нь батлагдах аль ч орны хувьд тайлангаа Хорооны 5-р сарын хуралдааны өмнө бэлтгэн ирүүлэхийг зөвлөдөг. ТӨАЖ нь 5-р сард биш 11-р сард батлагдсан тохиолдолд ч тухайн ТББ-аас 5-р сарын хуралдааны өмнө ирүүлсэн тайланг ашигладаг.

f. Тайланг хаашаа илгээх вэ?

Тайланг Хорооны Нарийн Бичгийн Даргын Газрын cat@ohchr.org цахим хаягаар илгээнэ. Түүнчлэн ТББ-ууд Хорооны гишүүн бүрт тайлангийнхаа хэвлэсэн хувийг өгөхийг хүсвэл дараах хаягаар 15 хэвлэмэл хувийг илгээж болно:

Secretariat to the Committee against Torture
Human Rights Treaties Division
Office of the United Nations High Commissioner for Human Rights (OHCHR)
Palais Wilson - 52, rue des Pâquis
CH-1201 Geneva (Switzerland)

3. Зэрэгцээ тайлангийн агуулга ба хэлбэр

Зэрэгцээ тайланг хэрхэн бэлтгэх тухай хатуу тогтоосон хэлбэр байхгүй. Гэвч тайлангийн бүтцэд наад зах нь оршил, үндсэн хэсэг, дүгнэлт ба зөвлөмж гэсэн гурван гол хэсэг багтсан байвал зохино.

a. Цогц буюу сэдэвчилсэн тайлан

Зэрэгцээ тайланг бэлтгэхдээ дээрх хоёр хэлбэрийн аль нэгийг ашиглаж болно. Цогц тайлан нь конвенцийн зүйл заалт бүрт дүн шижилгээ хийдэг бол сэдэвчилсэн тайланд тухайн байгууллага төрөлжсөн чиглэлийнхээ дагуу тодорхой салбар буюу сэдэвт голлон анхаардаг. Чухам аль хэлбэрийг сонгох нь та бүхнээс хамаарах бөгөөд танай байгууллагын чадамж хийгээд үйл ажиллагааны гол чиглэлээс мөн шалтгаална.

b. Агуулга

i. АЖ ба ТӨАЖ батлахад зориулсан тайлан

Хороо НҮБ-ын ЭШЭК-ийг үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбоотой хамгийн чухал асуудлын жагсаалтыг гаргадаг. Энэхүү жагсаалт нь нэгдэн орсон улсын тайланг хянан хэлэлцэх үед Хороо чухам юун дээр анхаарах ёстойг харуулдаг учраас ТББ-ууд Хороо ямар хэрэг тохиолдол, сэдэв, хүрээг нэн тэргүүнд анхаарч, гүнзгийрүүлэн шалгах шаардлагатайг тодорхойлоход түлхэц өгч, өөрсдийн байр суурийг нотлох мэдээллээр хангах нь амин чухал юм.

ii. Нэгдэн орсон улсын тайлантай холбоотой тайлан

Энэхүү тайлан нь тухайн улсын тайланд нэмэлт болохоос гадна уг тайлангийн талаар санал дүгнэлт өгч, түүнд оруулах нэмэлт болон орхигдсон мэдээллийг багтаасан байдаг. Хамгийн гол нь юу, хаана, хэзээ, хэн, яагаад, яаж гэсэн асуултад хариулт өгч чадахуйц байх ёстой.

iii. Зөвлөмжийг хэрэгжүүлэх явцын талаар мэдээлэл өгөх

Нэгдэн орсон улс Хорооноос өгсөн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар бүрэн дүүрэн мэдээлэл хомс байдаг. Тиймээс Хорооны зүгээс нөхцөл байдалд илүү үр дүнтэй хяналт тавихад нь туслах үүднээс ТББ-ууд Хорооны зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг мэдээлэхийн сацуу хэрэгжилтэд учирч байгаа хүндрэл бэрхшээлийн талаар сануулах, мөн нэгдэн орсон улс зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа талаар мэдэгдэж байх нь зүйтэй.

c. Баттай тоо баримт ашиглаж, мэдлэг туршлагаа хуваалцах

Зэрэгцээ тайланд дурдагдсан аливаа асуудал статистик тоо баримт, тодорхой жишээ баримт буюу хүний эрхийн зөрчлийн жишээ зэргээр дэмжигдсэн тохиолдолд илүү үр дүнтэй байдаг. Тухайн улсын хоёр тайлангийн хоорондох хугацаанд статистик тоо баримт цуглуулж илгээх нь зэрэгцээ тайлангийн үнэ цэн, ач холбогдлыг өсгөдөг.

d. Хэмжээ

Тайланг аль болох ойлгомжтой хэл найруулгаар, товч бичих нь зүйтэй. Маш сайн бичигдсэн товч тайлан нь та бүхний онцлохыг хүссэн асуудал дээр Хороо анхаарлаа төвлөрүүлэх нөхцлийг хангадаг.

e. ЭШЭХ-нд ирүүлсэн сайн бичигдсэн зэрэгцээ тайлангийн жишээ:

- Эмнести Интернэшнлийн Мексикийн тухай зэрэгцээ тайлан (2012)³ (сэдэвчилсэн тайлан)
- АРСТ-ийн Албаний тухай зэрэгцээ тайлан (2012)⁴ (тайлангийн нэмэлт процедур)
- Канадын АЖ-ыг батлахтай холбогдуулан гаргасан ССЛА-ийн тайлан (2012)⁵

4. Чухал хэрэгцээтэй бусад мэдээллийн сурвалж:

НҮБ-ын ЭШЭК-ийг соёрхон баталсан, тайлбар хийсэн болон мэдэгдэл гаргасан орнуудын тухай мэдээлэл http://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=IV-9&chapter=4&lang=en

НҮБ-ын ЭШЭК-ийн Нэмэлт Протоколыг соёрхон баталсан, тайлбар хийсэн болон мэдэгдэл гаргасан орнуудын тухай мэдээлэл http://treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=IV-9-b&chapter=4&lang=en

НҮБ-ын чуулган, хуралдаан, арга хэмжээний хуанли, цагийн хуваарь <http://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/Meetings.aspx>

³ http://www2.ohchr.org/english/bodies/cat/docs/ngos/AI_Mexico_CAT49_en.pdf

⁴ <http://www2.ohchr.org/english/bodies/cat/cats48.htm>

⁵ <http://www2.ohchr.org/english/bodies/cat/cats48.htm>

<http://www2.ohchr.org/english/bodies/cat/follow-procedure.htm>

ЭШЭХ-ны хуралдаан, нэгдэн орсон улс бүртэй холбоотой баримт бичиг <http://www2.ohchr.org/english/bodies/cat/sessions.htm>

ЭШЭХ-ны хурлын дэг <http://tb.ohchr.org/default.aspx?Symbol=CAT/C/3/Rev.5>

Иргэний болон Улс Төрийн Эрхийн Төвөөс эрхлэн хэвлүүлсэн НҮБ-ын Хүний Эрхийн Хороонд ТББ-уудаас зэрэгцээ тайлан бэлтгэн илгээх заавар <http://www.ccprcentre.org/publication/ngo-guidelines-on-the-reporting-process-of-the-un-human-rights-committee/>

ХАВСРАЛТ 1. Тайлангийн нэмэлт процедурыг хүлээн зөвшөөрсөн улсуудын жагсаалт (2013 оны 1-р сарын байдлаар)

2007 онд Эрүүдэн Шүүхийн Эсрэг Хороо нэгдэн орсон улсуудын зүгээс Хороонд ирүүлэх ёстой мэдээллийн хэмжээг багасгах замаар тайлангийн үйл явцыг хөнгөвчлөх зорилготой тайлангийн нэмэлт процедурыг баталсан билээ. Нэгдэн орсон улсуудаас ТӨАЖ-д ирүүлсэн тайлан, хариултын талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын вэб хуудасны “Тайлангийн нэмэлт процедур” гэсэн хэсгийг үзнэ үү.⁶

Алжир	Исланд	Серби
Аргентин	Израйл	Словак
Австрали	Ирланд	Словени
Австри	Итали	Испани
Азербейжан	Япон	Швед
Бельги	Йордан	Швейцарь
Белиз	Кени	Филиппин
Бенин	Солонгос	Турк
Боливи	Кувейт	Туркменистан
Босни ба Герцеговин	Киргизстан	Уганда
Бразил	Латви	Украйн
Болгар	Литва	АНУ
Камбож	Ливи	Уругвай
Чад	Лихтенштейн	Узбекистан
Чили	Люксембург	Замби
Хятад	Македони	
Колумби	Мальта	
Коста Рика	Мавритани	
Хорват	Мексик	
Кипр	Молдав	
Чех	Монгол	
Дани	Монако	
Эквадор	Монтенегро	
Эль Сальвадор	Марокко	
Эстони	Голланд	
Финланд	Шинэ Зеланд	
Гүрж	Норвеги	
Гана	Парагвай	
Грек	Перу	
Гватемала	Польш	
Гюана	Португаль	
Гондурас	Румын	
Унгар	ОХУ	

⁶ <http://www2.ohchr.org/english/bodies/cat/reporting-procedure.htm>